

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод .....	5
хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	12
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	15
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ХҮҮХЭЛДЭЙН ТЕАТРЫН  
ЗАХИРАЛ М.ОТГОНЧИМЭГ ТАНАА

2020.02.27 № 06/615  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын хүүхэлдэйн театрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын хүүхэлдэйн театрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын хүүхэлдэйн театрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус Улсын хүүхэлдэйн театрт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2.Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Улсын хүүхэлдэйн театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Улсын хүүхэлдэйн театрын захирал М.Отгончимэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үндсэн үйл ажиллагааны орлого, НБББББ, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын хүүхэлдэйн театрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын хүүхэлдэйн театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр 6-ны өдрөөс, 2019 оны 2 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Сүлд-Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын хүүхэлдэйн театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Улсын хүүхэлдэйн театрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь төрөөс баримтлах соёлын бодлогын хүрээнд бүх нийтэд соёл урлагаар үйлчлэхэд оршино.

Улсын хүүхэлдэйн театр үйл ажиллагааны чиглэлээ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Үе үеийн хүүхэд багачуудыг дэлхийн болон үндэсний сонгодог уран бүтээлүүдээр дамжуулж урлаг, гоо зүйн мэдрэмжийг олгох;
2. Мэргэжлийн урлагийн байгууллага, хүүхэлдэйн урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага хүмүүс, уран бүтээлчид, ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор судалгаа хийн, сургалт явуулж, мэдээлэл арга зүйн удирдлагаар хангах;
3. Эх орны болон дэлхийн сонгодог урлаг, соёлын ховор нандин өв, эх сурвалжийг эрэн сурвалжилж, театрын сан хөмрөгт хадгалагдаж буй урлагийн бүтээлийг сэргээх, баяжуулах, мэдээллийн сан бий болгох.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөх Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалаар “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам” батлагдсан байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн боловч өөрийн байгууллагын онцлогт тохирсон зарим заалт байхгүй байна.

Улсын хүүхэлдэйн театр нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Accolous” программ хангамж ашигладаг байна.

Улсын хүүхэлдэйн театрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Улсын хүүхэлдэйн театрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 440,259.0 мянган төгрөгөөс тооцон 4,402.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6,332.9 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардлын дүн 633,289.4 мянган төгрөг зарцуулсантай холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Улсын хүүхэлдэйн театрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63,726.7 мянган төгрөгөөр буюу 92.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцооны дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Авлага	107.1	-	107.1
Бараа материал	15,737.7	29,577.1	13,839.4
Үндсэн хөрөнгө	52,961.3	102,955.7	49,994.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>68,806.1</b>	<b>132,532.8</b>	<b>63,726.7</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	68,806.1	132,532.8	63,726.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>68,806.1</b>	<b>132,532.8</b>	<b>63,726.7</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 13,839.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 34,129.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь шинээр 63,425.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авснаас шалтгаалжээ. Үүнээс нэмэлт санхүүжилтээс 37,323.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан байна.

Биет бус хөрөнгө 12,000.0 мянган төгрөгөөр өссөн нь тасалбар худалдаалах вебсайт худалдаж авснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 132,532.8 мянган төгрөг болж 63,726.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Соёл урлагийн хөтөлбөрт зориулан 443,423.1 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд санхүүжилт батлагдаагүй боловч урсгал зардлын төсвөөс 26,102.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 443,128.5 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа бөгөөд зарцуулагдаагүй үлдэгдэл 294.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Хандив тусламжаар Швейцарийн хөгжлийн агентлагаас 35,000.0 мянга, Соёл урлагийн газраас 13,100.0 мянга, Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 109,978.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 95,515.0 мянган төгрөг буюу нийт 253,593.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс эд хогшил урсгал засварын зардалд 32,140.0 мянга, томилолтын зардалд 5,728.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 180,221.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 35,504.0 мянган төгрөг буюу нийт 253,593.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд 12 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 764.0 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах залруулагдаагүй 764.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Нярав тоглолтын тасалбарыг борлуулахдаа орлого бүрийг посын машинаар /е-баримтын/ уншуулдаггүй, нягтлан бодогч тогтмол хяналт тавьж орлого, үлдэгдлийг баталгаажуулдаггүйгээс 12 дугаар сарын кассын орлогыг е-баримтын бүртгэл тайлантай тулгахад 435.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна .

### Шийдвэрлэсэн нь:

Бүртгэл тайланд тусгаагүй 435.0 мянган төгрөгийн орлогыг төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

2. Хөдөө орон нутагт тоглосон жүжгийн 94 ширхэг билетийн 329.0 мянган төгрөгийн тоглолтын орлогыг бүртгээгүй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 294 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын 4.1.2-д “Тухайн салбар, байгууллагын аж ахуй, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны бүртгэлийн батлагдсан загвар аргачлалын дагуу бүртгэж, баримтын бүрдэлтэд хяналт тавих” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Шийдвэрлэсэн нь:

Бүртгэл тайланд тусгаагүй 329.0 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр акт тогтоох.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.



## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд хийгдэж байгаа уран бүтээлийн тоглолтын орлого, түүнд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болдог орлогын төлөвлөгөөг батлуулаагүй байгаа тул гол анхаарах асуудлаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 107 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4,442.4 мянган төгрөгийн зөрчилд нийт 6 зөвлөмж өгснөөс 6 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Улсын хүүхэлдэйн театрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 764.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 6,332.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй ” дүгнэлт

Улсын хүүхэлдэйн театрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Тус байгууллагын “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт” үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг УСНББОУС17 заалтыг баримтална гэсэн боловч стандартын 72 дугаар заалтын дагуу байгууллага өөрийн хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоосон заалт оруулаагүй байгаа нь дээрх стандарттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Хөрөнгийн ашиглагдах хугацаа буруу тодорхойлогдох, зардал буруу илэрхийлэгдэх

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Улсын хүүхэлдэйн театр нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлж сайжруулах.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

УСНББОУС 17-гийн Үндсэн хөрөнгийн 72 дугаар заалтыг мөрдөж ажиллана.

#### **3.2 Дотоод хяналттай холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Үндсэн үйл ажиллагааны орлогоос орсон орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч төрийн сан дахь бүртгэлийн дансанд орлого хүлээн авснаас хойш зарим тохиолдолд 3-10 хоногт тушаасан нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2.2 Эрсдэл:

Бэлэн мөнгө дутагдах

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллах, мөн энэ журмын 7.2-д "Мөнгөн кассын нярав бэлэн мөнгөний гүйлгээ тус бүрийг кассын дэвтэрт бүртгэж, өдөр бүр кассын тайлан гаргаж кассын дэвтрийн хуудас бүрийг дугаарлан дэвтрийн сүүлчийн хуудасны тоог бичиж дараагийн ажлын өдрийн 12 цагаас хэтрүүлэхгүйгээр нягтлан бодогчид шилжүүлэн өгч хянуулж байна" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Мөнгөн кассын журмыг хэрэгжүүлж ажиллана.

### 3.3.1. Илрүүлэлт:

Кассын нярав тоглолтын тасалбарыг хариуцаж, давхар тоглолтын тасалбарыг борлуулж байгаа нь Сангийн сайдын 2012 оны 294 дугаар тушаалаар баталсан "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ын 4.1.9-д "Үнэт цаас, тооцоот маягыг эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хэвлүүлж, түүний хадгалалт, зарцуулалтад хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй, хэмжилт, үнэн зөв байдал, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.3.2 Эрсдэл:

Орлогоо бүрэн тусгахгүй байх

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Кассын няравын давхар хариуцаж байгаа тоглолтын билетийн үнэт цаасыг тодорхой хяналттайгаар зарлага гаргаж билетийг дугаарлан анхан шатны баримт бүрдүүлж дотоод хяналтыг сайжруулах.

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид үнэт цаасанд хяналт тавьж ажиллана.

### 3.4.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын балансад ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн ч ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгө, нийт үндсэн хөрөнгийн 82.5 %-ийг эзэлж байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолын 7 дахь заалт, УСНББОУС 17-той нийцэхгүй, үнэн зөв, оршин байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### 3.4.2 Эрсдэл:

Хөрөнгө үнэгүйтэх, элэгдлийн зардал буруу тооцогдох

### 3.4.3 Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг дахин үнэлэх асуудлыг шийдвэрлэх.

### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид анхаарч 2020 онд хөрөнгөө дахин үнэлүүлнэ.

### **3.5.1. Илрүүлэлт:**

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, байхаар төлөвлөж зарцуулах”, Сангийн Сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3.4.3-т заасан “Үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

### **3.5.2 Эрсдэл:**

Төсвийн төлөвлөгөөг үндэслэлгүй батлуулах, үргүй зардал гаргах

### **3.5.3 Өгсөн зөвлөмж:**

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг дээд шатны байгууллагаар батлуулан зөрчлийг давтан гаргахгүй байх

### **3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг батлуулж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>15,844,846.28</u></b>	<b><u>29,577,141.92</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	107,146.36	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	107,146.36	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	15,737,699.92	29,577,141.92
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	2,818,988.92	2,330,488.92
35110	Тусгай зориулалттай материал	2,818,988.92	2,330,488.92
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	12,918,711.00	27,246,653.00
35410	Бичиг хэргийн материал	147,900.00	382,120.00
35420	Аж ахуйн материал	154,536.00	202,138.00
35440	Түлш, шатах тослох материал	195,000.00	1,225,000.00
35450	Барилгын засварын материал	98,795.00	3,594,115.00
35470	Бусад хангамжийн материал	12,322,480.00	21,843,280.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>52,961,270.58</u></b>	<b><u>102,955,695.63</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	52,961,270.58	102,955,695.63
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	52,826,270.58	90,865,695.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	4,200,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(17,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	676,375,997.00	687,151,487.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(665,163,638.18)	(669,315,291.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,249,385.00	57,854,385.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,680,371.83)	(42,967,131.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	63,476,508.00	91,921,958.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(33,684,547.41)	(40,615,148.54)
39217	Ном	2,252,938.00	2,652,938.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	135,000.00	12,090,000.00
39301	Програм хангамж	1,170,000.00	13,170,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,035,000.00)	(1,080,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>68,806,116.86</u></b>	<b><u>132,532,837.55</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>68,806,116.86</u></b>	<b><u>132,532,837.55</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	68,806,116.86	132,532,837.55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	810,567,666.94	810,567,666.94
51101	Өмч: - төрийн	810,567,666.94	810,567,666.94
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(743,380,131.08)	(679,653,410.39)
51210	Өмнөх үеийн үр дүн	(743,380,131.08)	(743,380,131.08)
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	63,726,720.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,618,581.00	1,618,581.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>68,806,116.86</u></b>	<b><u>132,532,837.55</u></b>

#### 4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>441,272,895.00</b>	<b>697,016,100.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>384,198,895.00</b>	<b>697,016,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	323,205,900.00	443,423,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	323,205,900.00	443,423,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	60,992,995.00	253,593,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	35,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,100,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,892,995.00	218,593,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>440,259,640.23</b>	<b>633,289,379.31</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>440,259,640.23</b>	<b>633,289,379.31</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	431,214,333.89	593,895,737.55
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	240,344,799.82	327,460,700.00
210101	Үндсэн цалин	197,621,990.31	218,821,296.08
210102	Нэмэгдэл	21,810,489.51	88,597,503.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,912,320.00	20,041,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,512,847.48	40,745,104.60
210201	Тэтгэврийн даатгал	21,805,735.17	27,633,475.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,680,832.82	3,251,120.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,254,632.78	2,707,902.88
210204	Ажилгүйдлийн даатгал	352,396.34	650,364.13
210205	Эрүүл мэндийн даатгал	3,419,250.37	6,502,241.33
